



**НИЙСЛЭЛИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТОГТООЛ**

2022 оны 11 сарын 17 өдөр

Дугаар 104

Улаанбаатар хот

**Нийслэлийн өмчийн бүртгэлээс
барилга байгууламж хасах тухай**

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.11 дэх заалт, 48 дугаар зүйлийн 48.1 дэх хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1 дэх хэсэг, 77 дугаар зүйлийн 77.1 дэх хэсэг, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны 66 дугаар тогтоолыг тус тус үндэслэн Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас ТОГТООХ нь:

1. Улсын төсвийн хөрөнгө оруулалт болон Азийн хөгжлийн банкны санхүүжилтээр шинээр эмнэлгийн барилга баригдах болсонтой холбогдуулан Нийслэлийн Мэргэжлийн хяналтын газрын Улсын байцаагчийн дүгнэлтээр ашиглалтын шаардлага хангахгүй болох нь тогтоогдсон, Баянзүрх дүүрэг дэх нийт 184,274,033.26 (нэг зуун наян дөрвөн сая хоёр зуун далан дөрвөн мянга гучин гурван төгрөг хорин зургаан мөнгө) төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий, хавсралтад дурдсан 2 барилга байгууламжийг акталж, нийслэлийн өмчийн бүртгэлээс хасахыг Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч (Д.Сумъяабазар)-д зөвшөөрсүгэй.

2. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Эдийн засаг, төсвийн хороо (М.Халиунбат)-нд даалгасугай.

ДАРГА



Ж.БАТБАЯСГАЛАН

1110100371

Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны 11 дүгээр сарын 17-ны өдрийн 104 дүгээр тогтоолын хавсралт



НИЙСЛЭЛИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛЭЭС ХАСАХ БАРИЛГА БАЙГУУЛАМЖИЙН ЖАГСААЛТ

№	Барилга байгууламжийн нэр	Ашиглалтад орсон он	Байршил	Бүртгэлийн үнэ	Хуримтлагдсан элэгдэл /2022.09.30/	Үлдэгдэл өртөг /2022.09.30/	Акталж, данснаас хасах үндэслэл
1	Баянзүрх дүүргийн 17 дугаар хорооны өрхийн эрүүл мэндийн төвийн хуучин барилга	2001	Баянзүрх дүүрэг, 17 дугаар хороо, "Да хүрээ" захын замын эсрэг талд, "Эрдэнэ" төвийн чанх урд	94,628,000	36,706,658.69	57,921,341.31	Нийслэлийн Мэргэжлийн хяналтын газрын Улсын байцаагчийн 2019 оны 02-07-091/1307 дугаар дүгнэлт
2	Баянзүрх дүүргийн 20 дугаар хороо, Гачуурт тосгоны Эрүүл мэндийн төвийн барилга, байгууламж	1961	Баянзүрх дүүрэг, 20 дугаар хороо, Гачуурт тосгоны төвд	89,646,033.26	50,623,074.87	39,022,958.39	Нийслэлийн Мэргэжлийн хяналтын газрын Улсын ахлах байцаагчийн 2012 оны 02-07-79/688 дугаар дүгнэлт
НИЙТ ДҮН				184,274,033.26	87,329,733.56	96,944,299.70	